



MOTCAPITAL

Үйлчилгээний Нөхцөл

Улаанбаатар хот

Нэмэлт, Өөрчлөлт

Он,сар, өдөр	Зүйл, заалт	Өөрчлөлт	Хувилбар
2025.03.20		Шинэчилсэн найруулга	1.0
2025.05.21	5.1.3, 5.3.3	5.1.1 Хэрэглэгч өөрийн дансыг 30 хоног ашиглаагүй буюу идэвхгүй ашигласан тохиолдолд арилжааны дансыг хааж, цахим шуудангаар мэдэгдэнэ. 5.3.3 Хэрэглэгч арилжааны дансандаа нээлттэй арилжаатай тохиолдолд дотоод шилжүүлэг хийх боломжгүй болно.	1.1
2025.08.14	2.1.1, 2.1.2, 7-р бүлэг	2.1.1 “Динамик хөшүүрэг” гэж хэрэглэгчийн нээлттэй арилжааны лотны хэмжээ болон зах зээлд өндөр нөлөө үзүүлдэг мэдээний үед өөрчлөгддөг хөшүүргийг; /2025.08.14-ний нэмэлт, өөрчлөлт болно/ 2.1.2 “Өндөр нөлөө үзүүлдэг мэдээ” гэж үйлчилгээ үзүүлэгчийн веб сайтад байршуулсан мэдээний жагсаалтанд багтсан, 2 ба түүнээс дээш одтой мэдээг; /2025.08.14-ний нэмэлт, өөрчлөлт болно/ Долоо.Хөшүүрэг бүлэг нэмэгдэв.	1.2

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Үйлчилгээний нөхцөл” /цаашид **“Нөхцөл”** гэх/-ийн зорилт нь үйлчилгээ үзүүлэгч **“МOT Капитал” ХХК** болон олон улсын зах зээлийн форе́кс арилжаанд оролцох хүсэлтэй, энэхүү нөхцөлтэй танилцсан, хүлээн зөвшөөрсөн иргэн /цаашид **“Хэрэглэгч”** гэх/ нарын хооронд байгуулагдсан **“Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ”**-гээр зохицуулагдаагүй харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү нөхцөл нь Монгол Улсын Иргэний хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэх ба Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
- 1.3. **“Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ”**-ний энэхүү хавсралт нь гэрээний адил хүчин төгөлдөр үйлчлэх ба гэрээ болон гэрээний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний адил хүчин төгөлдөр байна.
- 1.4. Энэхүү **“Үйлчилгээний нөхцөл”** болон **“Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ”**-нд заагдаагүй үйлчилгээний нөхцөл, дүрмийг тухай бүрт нь гаргаж, хэрэглэгчийн и-мэйл болон өөрийн цахим хуудсаар мэдэгдэнэ.

ХОЁР.НЭР ТОМЬЁО

- 2.2. Энэхүү нөхцөлд дурьдагдах нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 **“Форе́кс арилжаа”** гэж олон улсын зах зээл дээрх гадаад валют, үнэт метал, хувьцаа, виртуал хөрөнгө зэрэг хослолд арилжаа хийх боломжтой зах зээлийг;
 - 2.1.2 **“Платформ”** гэж олон улсын зах зээлийн арилжаанд оролцох боломжтой MetaTrader 5 болон Ctrader программыг;
 - 2.1.3 **“Бүртгэл”** гэж <https://www.motcapital.com>-д үүсгэсэн бүртгэлийг;
 - 2.1.4 **“Мөнгө угаах”** гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;
 - 2.1.5 **“Терроризмыг санхүүжүүлэх”** гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;
 - 2.1.6 **“Бүртгэлийн маягт”** гэж хэрэглэгчийн хувийн мэдээллийг баталгаажуулах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч буй асуулгыг;
 - 2.1.7 **“Хэрэглэгч”** гэж 18 ба түүнээс дээш насны эрх зүйн бүрэн чадамжтай, олон улсын зах зээлийн арилжаанд MetaTrader 5 болон Ctrader платформоор оролцох хүсэлтэй, <https://www.motcapital.com>-д бүртгэлтэй хэрэглэгчийг;
 - 2.1.8 **“Хувийн мэдээлэл баталгаажуулалт буюу KYC”** гэж хэрэглэгч өөрийн иргэний үнэмлэх, оршин суугаа хаягийн лавлагаа болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг илгээж, бүртгэлээ баталгаажуулахыг;
 - 2.1.9 **“Баталгаажсан хэрэглэгч”** гэж арилжааны платформд данс үүсгэх, өөрийн дансны гүйлгээг удирдах боломжтой, хувийн мэдээллээ баталгаажуулсан хэрэглэгчийг;
 - 2.1.10 **“Арилжааны жинхэнэ данс”** гэж арилжааны платформуудад нэвтрэх эрхтэй, өөрийн дансанд орлого хийж арилжаанд оролцох боломжтой дансыг;
 - 2.1.11 **“Демо данс”** гэж арилжааны платформуудад нэвтрэх эрхтэй, \$10,000 хэмжээтэй арилжаанд оролцох боломжтой, нэмэлтээр орлого хийх болон зарлага гаргах боломжгүй туршилтын дансыг;

- 2.1.12 “Хөшүүрэг” гэж өөрийн арилжааны жинхэнэ дансны үлдэгдлээр илүү өндөр хэмжээний үнийн дүнд хүрэлцэхүйц арилжаанд орох боломжийг нээж өгдөг хэрэгслийг;
- 2.1.13 “Орлого” гэж <https://www.motcapital.com-ийр> ашиглан өөрийн үүсгэсэн арилжааны жинхэнэ дансанд орлого хийх үйлдлийг;
- 2.1.14 “Шилжүүлэг” гэж <https://www.motcapital.com-д> үүсгэсэн, өөрийн арилжааны жинхэнэ данснуудын хооронд зөвхөн шилжүүлэг хийх үйлдлийг;
- 2.1.15 “Зарлага” гэж <https://www.motcapital.com-ийг> ашиглан өөрийн үүсгэсэн арилжааны жинхэнэ данснаас зарлага гаргах үйлдлийг;
- 2.1.16 “Дагуулагч” гэж энэхүү үйлчилгээний нөхцөлийн 6.1-т заасан шаардлагыг хангасан арилжаач;
- 2.1.17 “Дагагч” гэж энэхүү үйлчилгээний нөхцөлийн 2.1.16-т заасан Дагуулагчийн арилжааг дагагчийг;
- 2.1.18 “Копи арилжаа” гэж Дагуулагчийн арилжааг хуулбарлах үйлчилгээг;
- 2.1.19 “Копи арилжааны үйлчилгээний нөхцөл” гэж Дагуулагчийн арилжааг хуулбарлах үйлчилгээний веб сайтад байршсан нөхцөл;
- 2.1.20 “Хязгаарлалтын арга хэмжээ” гэж Үйлчилгээ үзүүлэгчид “Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ”-гээр олгогдсон эрхийн хүрээнд Хэрэглэгчийн арилжааны дансыг түр хязгаарлах, бүрэн хориглох, дахин нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, арилжааны тохируулга хийх, компанийн хар жагсаалтанд оруулах, гэрээ цуцлах, ашгийг хүчингүйд тооцох үйлдлийг;
- 2.1.21 “Дүрэм зөрчсөн арилжаа” гэж “Хеджинг” буюу Hedging, “Арбитраж” буюу Arbitrage, “Бот” буюу Bot, “Мэргэжлийн зөвлөгч” буюу Exper Adviser, “Робот” буюу Robot ашигласан арилжааны үйлдлийг;
- 2.1.22 “Хеджинг” гэж хэрэглэгч 2 ба түүнээс дээш дансаар эсрэг арилжаа нээх, нэг IP хаягаас эсрэг арилжаа нээх үйлдлийг;
- 2.1.23 “Ролл-овер” буюу Roll over гэж гэрээний хугацаа дуусах үед дараагийн шинэ гэрээнд шилжих стандарт үйл явцыг; [/2025.03.20-ны нэмэлт, өөрчлөлт болно/](#)
- 2.1.24 “Арилжааны дансны тохируулга” буюу Adjustment гэж ханш нийлүүлэгч буюу олон улсын зах зээлийн арилжааны платформоос ирүүлсэн фьючерс ролл-оверын дагуу болон хасах балансын зарчмын дагуу арилжааны дансанд хийсэн үйлдлийг; [/2025.03.20-ны нэмэлт, өөрчлөлт болно/](#)
- 2.1.25 “Динамик хөшүүрэг” гэж хэрэглэгчийн нээлттэй арилжааны лотны хэмжээ болон зах зээлд өндөр нөлөө үзүүлдэг мэдээний үед өөрчлөгддөг хөшүүргийг; [/2025.08.14-ний нэмэлт, өөрчлөлт болно/](#)
- 2.1.26 “Өндөр нөлөө үзүүлдэг мэдээ” гэж үйлчилгээ үзүүлэгчийн веб сайтад байршуулсан мэдээний жагсаалтанд багтсан, 2 ба түүнээс дээш одтой мэдээг; [/2025.08.14-ний нэмэлт, өөрчлөлт болно/](#)
- 2.1.27 “Үйлчилгээний хураамж” гэж үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлсэн үйлчилгээний зардалд тооцож, хэрэглэгчээс суутгах төлбөр;

ГУРАВ.ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 3.1. Хэрэглэгч нь энэхүү нөхцөл болон гэрээ, бүртгэлийн маягтад заасан нөхцөлүүдтэй танилцаж, хүлээн зөвшөөрснөөр “МOT Капитал” ХХК-ийн <https://www.motcapital.com> веб сайтад бүртгэл үүсгэх, цаашид бидний үйлчилгээг ашиглах эрх үүснэ.
- 3.2. Хэрэглэгч нь энэхүү нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан дарааллын дагуу өөрийн бүртгэлээ үүсгэх ба “МOT Капитал” ХХК нь энэхүү нөхцөлийн 4.2.3-т заасан шаардлагыг хангасан хэрэглэгчийн бүртгэлийг баталгаажуулна.
- 3.3. Баталгаажсан хэрэглэгч энэхүү нөхцөлийн 5 дугаар зүйлд заасны дагуу арилжааны данс нээж, орлого хийснээр арилжаанд оролцох боломжтой болно.
- 3.4. Үйлчилгээ үзүүлэгчээс аливаа урамшуулал, хөнгөлөлт, хөтөлбөрүүдийг зарлах эрхтэй ба бусад төрлийн нэмэлт үйлчилгээний дүрмийг тухай бүрт нь олон нийтэд танилцуулна.
- 3.5. Энэхүү нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах эрх нь зөвхөн “МOT Капитал” ХХК-д байх ба өөрийн цахим хуудсаар дамжуулан нэмэлт, өөрчлөлтийг хэрэглэгчид мэдэгдэнэ.

- 3.6. Хэрэглэгч энэхүү нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд гэрээ цуцлах, бүртгэлээ устгах хүсэлт гаргах эрхтэй.

ДӨРӨВ. БҮРТГЭЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ

4.1. Бүртгэл

- 4.1.1 Хэрэглэгч <https://www.motcapital.com> веб сайтад зөвхөн өөрийн овог, нэр, регистрийн дугаар, цахим шуудангийн хаяг, холбоо барих мэдээлэл, утасны дугаарын мэдээллээр бүртгүүлнэ.
- 4.1.2 Хэрэглэгч энэхүү нөхцөлийн 4.2.3-т заасан шаардлага хангаагүй тохиолдолд хэрэглэгчийн бүртгэл үүсгэх, данс нээх, үйлчилгээ үзүүлэх боломжгүй.
- 4.1.3 Хэрэглэгч бүртгэл үүсгэснээс хойш 30 хоногийн хугацаанд өөрийн арилжааны дансанд орлого хийгээгүй тохиолдолд арилжааны дансыг хааж, хэрэглэгчийн и-майл хаягаар мэдэгдэнэ.

4.2. Баталгаажуулалт

- 4.2.1 Хэрэглэгчийн бүртгэл үүссэн тохиолдолд хэрэглэгч хувийн мэдээлэл баталгаажуулах иргэний үнэмлэхийн лавлагаа, оршин суугаа хаягийн лавлагаа болон бусад нэмэлт шаардлагатай баримт бичгүүдийг илгээнэ.
- 4.2.2 Хувийн мэдээлэл баталгаажуулах хүсэлтийг ажлын 3 хоногийн дотор хянан шалгаж, мэдээллийг үнэн зөвд тооцсон тохиолдолд хувийн мэдээллийг баталгаажуулна.
- 4.2.3 Дараах шаардлагыг хангасан хэрэглэгчийн хувийн мэдээллийг баталгаажуулах болно. Үүнд:
- 4.2.3.1 Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ болон үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн;
- 4.2.3.2 18 ба түүнээс дээш насны эрх зүйн бүрэн чадамжтай;
- 4.2.3.3 Хувийн мэдээлэл болон бүртгэлийн маягыг алдаагүй, үнэн зөв, бүрэн бөглөсөн;
- 4.2.3.4 Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэн явуулдаг банканд бүртгэлтэй, өөрийн нэр дээрх данстай;
- 4.2.3.5 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжинд заасан эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж байсан эсхүл холбогдож байсан, аливаа хязгаарлалт, хориглолтонд ороогүй гэдгээ баталсан;
- 4.2.3.6 Давхар бүртгэл үүсгэсэн;
- 4.2.3.7 Компанийн хар жагсаалтанд багтаагүй хэрэглэгчийн хувийн мэдээллийг баталгаажуулна.
- 4.2.4 Хэрэглэгчийн хувийн мэдээллийг зургаар болон sumsub автомат платформоор эсхүл Монгол Улсын танилт нэвтрүүлэлтийн ДАН системээр баталгаажуулна.
- 4.2.5 Хэрэв хэрэглэгчийн мэдээлэл алдаатай, дутуу, хуурамч, хуучирсан байх тохиолдолд хэрэглэгчээс дахин шинэчлэхийг шаардах эсхүл үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- 4.2.6 Энэхүү нөхцөлийн 4.2.3-т заасан шаардлагыг хангаагүй хэрэглэгч хуурамч баримт бичиг ашиглан хувийн мэдээллээ баталгаажуулсан байх тохиолдолд учирсан хохирлыг түүний эцэг, эх асран хамгаалагчаас гаргуулан, нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэй.
- 4.2.7 Хэрэглэгч хувийн мэдээллээ баталгаажуулснаар бид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, залилан, луйвар болон бусад эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, маркетингийн сурталчилгаа илгээх зорилгоор хувь хүний мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах, арилжааны түүхийг шалгах эрхтэй болно.
- 4.2.8 Хэрэглэгч өөрийн хувийн мэдээллийг өөрчлөгдөх тохиолдол бүрт шинэчлэх шаардлагатай ба өөрчлөгдсөнтэй холбоотойгоор холбогдох боломжгүй болсон тохиолдолд гаргасан зардлыг хэрэглэгч хариуцана.

ТАВ. ДАНС НЭЭХ, ГҮЙЛГЭЭ ХИЙХ**5.2. Данс нээх**

- 5.1.1 Хувийн бүртгэлээ баталгаажуулсан хэрэглэгч өөрийн хэрэгцээнд тулгуурлан арилжааны жинхэнэ болон демо дансыг нээх боломжтой.
- 5.1.2 Хэрэглэгч өөрийн дансыг нээхдээ арилжаанд оролцох платформ /MetaTrader 5, cTrader/ болон хөшүүргийг /1:100-1000/ сонгох шаардлагатай.
- 5.1.3 Хэрэглэгч өөрийн дансыг 30 хоног ашиглаагүй буюу идэвхгүй ашигласан тохиолдолд арилжааны дансыг хааж, цахим шуудангаар мэдэгдэнэ. [/2025.05.21-ний нэмэлт, өөрчлөлт болно/](#)

5.3. Орлого хийх

- 5.2.1 Хэрэглэгч арилжааны дансандаа орлого хийх хамгийн доод хэмжээ нь \$25 /тухайн өдрийн ханшаар/ байна.
- 5.2.2 Хэрэглэгчийн орлогын хэмжээ 5 сая ба түүнээс доош хэмжээтэй бол тухайн өдөрт цаг хамаарахгүй 1-5 минутанд орох болно.
- 5.2.3 Хэрэглэгч 5 сая ба түүнээс доош хэмжээний орлого хийхдээ хувийн мэдээллээ баталгаажуулах шаардлагагүй болно.
- 5.2.4 Хэрэглэгчийн орлогын хэмжээ 5 сая ба түүнээс дээш хэмжээтэй бол тухайн өдрийн 17:00 цагаас хойш орох болно.
- 5.2.5 Хэрэглэгч 5 сая ба түүнээс дээш хэмжээний орлого хийхдээ хувийн мэдээллээ заавал баталгаажуулна.
- 5.2.6 Хэрэглэгчийн гүйлгээний дүн нь орлогын хүсэлттэй ижил байна. Хэрэв гүйлгээний утга эсхүл орлогын хүсэлтийг буруу бөглөсөн тохиолдолд хэрэглэгчийн үйлчилгээний албаны 7222-2200 дугаараар холбогдож шийдвэрлүүлнэ.
- 5.2.7 Хэрэглэгч 20 сая ба түүнээс дээш хэмжээний орлого хийсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчээс нэмэлт асуулгыг авч баталгаажуулна.
- 5.2.8 Хэрэглэгч криптогоор орлогын хүсэлт илгээсэн тохиолдолд зөвхөн криптогоор зарлага гаргах боломжтой ба банкны шилжүүлгээр орлого хийсэн тохиолдолд зөвхөн банкны шилжүүлгээр зарлага гаргана.

Банкны орлого

- 5.2.9 Хэрэглэгч гүйлгээний утга дээрээ өөрийн бүртгэлтэй и-майл хаягийг бичих бөгөөд буруу бичсэн тохиолдолд орлого хийгдэхгүй болно.
- 5.2.10 Хэрэглэгч арилжааны дансандаа зөвхөн өөрийн нэр дээрх арилжааны банкны гүйлгээгээр орлого хийх боломжтой бөгөөд гуравдагч этгээдийн данснаас шилжүүлсэн орлогын хүсэлт амжилтгүй болно.
- 5.2.11 Хэрэв хэрэглэгч энэхүү гэрээний 5.2 дугаар зүйлийн 5.2.1-т заасан хэмжээнээс бага дүнгээр орлого хийх эсхүл андуурагдсан гүйлгээ хийсэн тохиолдолд хэрэглэгчийн орлогыг ажлын 2-3 өдрийн дотор буцаан шилжүүлнэ.
- 5.2.12 Хэрэв хэрэглэгчийн бүртгэлд гуравдагч этгээдийн данснаас орлого шилжүүлвэл тухайн хэрэглэгчийг дансыг түр хязгаарлах, бүрэн хориглох, нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, арилжааны тохируулга хийх, компанийн хар жагсаалтанд оруулах, ашгийг хүчингүйд тооцох, гэрээ цуцлах, холбогдох хуулийн байгууллагад шалгуулах зэрэг арга хэмжээг авах болно.

Крипто орлого

- 5.2.13 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн крипто орлого, зарлагыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл бүхий компаниар дамжуулан гүйлгээг хийх болно.
- 5.2.14 Хэрэглэгч крипто хаягаа буруу бичсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь хариуцлага хүлээхгүй болно.
- 5.2.15 Хэрэглэгч арилжааны дансандаа зөвхөн өөрийн нэр дээрх крипто хаягаас орлого хийх боломжтой бөгөөд гуравдагч этгээдийн крипто хаягаас шилжүүлсэн орлогын хүсэлт амжилтгүй болох ба хэрэглэгч өөрийн шилжүүлгийн скрийншотыг манай албан ёсны фейсбүүк хуудсанд илгээснээр орлогын хүсэлт амжилттай болно.

- 5.2.16 Хэрэв хэрэглэгч энэхүү гэрээний 5.2 дугаар зүйлийн 5.2.1-т заасан хэмжээнээс бага дүнгээр орлого хийсэн тохиолдолд хэрэглэгчийн орлогыг ажлын 2-3 өдрийн дотор холбогдох шимтгэлийг хасч шилжүүлнэ.
- 5.2.17 Хэрэв хэрэглэгчийн бүртгэлд гуравдагч этгээдийн данснаас орлого шилжүүлвэл тухайн хэрэглэгчийн дансыг түр хязгаарлах, бүрэн хориглох, нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, арилжааны тохируулга хийх, компанийн хар жагсаалтанд оруулах, ашгийг хүчингүйд тооцох, гэрээ цуцлах, холбогдох хуулийн байгууллагад шалгуулах зэрэг арга хэмжээг авах болно.

Картын орлого

- 5.2.18 Хэрэглэгчийн картын орлогын хугацаа нь орлогын дүнгээс хамаарч 1-15 минутанд орно.
- 5.2.19 Хэрэглэгч арилжааны дансандаа зөвхөн өөрийн нэр дээрх виза, мастер, юнионпэй картаар орлого хийх боломжтой бөгөөд и-пин кодоор баталгаажуулснаар хэрэглэгчийн картыг баталгаажсанд тооцно.
- 5.2.20 Хэрэглэгч орлогын үнийн дүнг буруу бичсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь хариуцлага хүлээхгүй болно.

5.4. Шилжүүлэг хийх

- 5.3.1 Хэрэглэгч өөрийн арилжааны жинхэнэ данснууд хооронд чөлөөтэй шилжүүлэг хийх боломжтой ба гуравдагч этгээдийн дансруу шилжүүлэг хийх боломжгүй.
- 5.3.2 Хэрэглэгчийн шилжүүлэг хийх хүсэлтийг ажлын 12 цагийн дотор шийдвэрлэнэ.
- 5.3.3 Хэрэглэгч арилжааны дансандаа нээлттэй арилжаатай тохиолдолд дотоод шилжүүлэг хийх боломжгүй болно. [/2025.05.21-ний нэмэлт, өөрчлөлт болно/](#)

5.5. Зарлага гаргах

- 5.4.1 Хэрэглэгч данснаасаа зарлага гаргах хамгийн доод хэмжээ нь \$10 /тухайн өдрийн ханшаар/ байна.
- 5.4.2 Хэрэглэгчийн зарлагын хүсэлтийг ажлын 12 цагийн дотор шийдвэрлэж, Хэрэглэгчийн дансанд шилжүүлэх ба гүйлгээний дүн болон зарлагын төрлөөс хамааран Үйлчилгээ үзүүлэгчээс хамааралгүй шалтгаанаар зарлагын хүсэлт удаашрах боломжтой болно.
- 5.4.3 Хэрэглэгч криптогоор орлогын хүсэлт илгээсэн тохиолдолд зөвхөн криптогоор зарлага гаргах боломжтой ба банкны шилжүүлгээр орлого хийсэн тохиолдолд зөвхөн банкны шилжүүлгээр зарлага гаргана.

Банкны зарлага

- 5.4.4 Үйлчилгээ үзүүлэгч нь зөвхөн хувийн мэдээллээ баталгаажуулсан хэрэглэгчийн зарлагын хүсэлт амжилттай гүйцэтгэх ба зөвхөн өөрийн нэр дээрх арилжааны банкны гүйлгээгээр зарлага гаргах боломжтой болно.
- 5.4.5 Хэрэв хэрэглэгч энэхүү гэрээний 5.4 дугаар зүйлийн 5.4.1-т заасан хэмжээнээс бага дүнгээр зарлагын хүсэлт гаргасан эсхүл нээлттэй арилжаатай байх тохиолдолд хэрэглэгчийн зарлагын хүсэлт амжилтгүй болно.
- 5.4.6 Хэрэв хэрэглэгч гуравдагч этгээдийн дансанд зарлага гаргах хүсэлт гаргавал тухайн хэрэглэгчийг дансыг арилжааны тохируулга хийх, бүрэн хориглох, нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, компанийн хар жагсаалтанд оруулах, ашгийг хүчингүйд тооцох, гэрээ цуцлах, холбогдох хуулийн байгууллагад шалгуулах зэрэг арга хэмжээг авах болно.

Крипто зарлага

- 5.4.6 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн крипто орлого, зарлагыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл бүхий компаниар дамжуулан гүйлгээг хийх болно.
- 5.4.7 Хэрэглэгч өөрийн хүлээн авах крипто хаягаа буруу хийсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй болно.
- 5.4.8 Хэрэглэгч арилжааны данснаасаа зөвхөн өөрийн нэр дээрх крипто хаягт зарлага гаргах боломжтой бөгөөд гуравдагч этгээдийн крипто хаягт зарлага гаргах хүсэлт амжилтгүй болох ба зарлагын хүсэлт ажлын 12 цагийн дотор амжилттай болно.

Картын зарлага

- 5.4.9 Хэрэглэгч картаар орлого хийсэн тохиолдолд зөвхөн картаар зарлага гаргах боломжтой болно.

ЗУРГАА.КОПИ АРИЛЖАА /COPY TRADING/

- 6.1 Дараах шаардлагыг хангасан хэрэглэгч копи арилжаа үйлчилгээг Дагагчид санал болгох боломжтой. Үүнд:
- 6.1.1 Үндсэн арилжааны Стандарт, Про, Свинг дансаар 1 сар ба түүнээс дээш хугацаанд арилжаа хийсэн түүхтэй байх /багадаа 4 долоо хоног/;
- 6.1.2 Копи арилжаа үйлчилгээг санал болгох арилжааны дансны үлдэгдэл багадаа \$500 байх;
- 6.1.3 Үйлчилгээний шимтгэл хүлээн авах Стандарт данс нээсэн байх.
- 6.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Дагуулагчийн дараах мэдээллийг олон нийтэд нээлттэй дамжуулна.Үүнд:

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
1	Хувийн мэдээлэл	- Арилжааны туршлага - Эрсдэлийн үнэлгээ - Стратегийн тайлбар - Дагагчийн дансны доод хэмжээ - Үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ
2	Арилжааны дансны мэдээлэл	- Нийт ашиг - Нийт алдагдал - Хөшүүрэг
3	Арилжааны үзүүлэлт	- Арилжааны дансны үлдэгдэл - Ашгийн хувь - Дагагчийн тоо
4	Эрсдэлийн менежмент	- Хамгийн өндөр ашиг - Хамгийн өндөр алдагдал - Тогтмол ашигтай арилжсан арилжааны тоо
5	Арилжааны түүх	- Хаасан арилжааны түүх - Нээлттэй арилжааны түүх - Орлого, Зарлагын түүх

- 6.3 Үйлчилгээ үзүүлэгч нь <https://www.motcapital.com>-д бүртгэлтэй, баталгаажсан хэрэглэгчид копи арилжаа үйлчилгээг санал болгоно.
- 6.4 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах хувь, хэмжээг тогтооно. Үүнд:
- 6.4.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Дагагчийн арилжааны дансны доод хэмжээг тогтоох ба тухайн өдрийн ханшаар хамгийн багадаа \$100 ам.доллар байна.
- 6.4.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Дагуулагчийн арилжааг хуулбарлах үйлчилгээний шимтгэлийн дээд хязгаарыг тогтоох эрхтэй ба Дагагчийн ашгийн 0-30 хүртэлх хувь байна.
- 6.4.3 Дагуулагчийн арилжааг Дагагчийн дансны үлдэгдэлд үндэслэж, лотны хэмжээг автоматаар тохируулна.
- 6.5 Дагагч нь дараах хувь, хэмжээг тогтооно. Үүнд:
- 6.5.1 Дагагч нь Дагуулагчийн арилжааг хуулбарлахдаа ашгийн хэмжээ, алдагдлын хэмжээг тохируулах боломжтой ба хэрэв ашиг болон алдагдлын хэмжээнд хүрсэн тохиолдолд копи арилжаа үйлчилгээ зогсох болно.
- 6.5.2 Дагагч нь энэхүү нөхцөлийн 6.4.2-т заасан копи арилжаа үйлчилгээний шимтгэлийг төлөх өдрийг сонгох боломжтой ба копи арилжаагүй үедээ копи үйлчилгээг зогсоож болно.
- 6.5.3 Дагагч нь копи арилжааг ашиглан ашигтай байх үедээ копи арилжааны үйлчилгээг зогсоох тохиолдолд тухайн ашгаас энэхүү нөхцөлийн 6.4.2-т заасан үйлчилгээний шимтгэлийг Дагуулагчид төлнө.
- 6.6 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрсдэлийг хариуцахгүй болно. Үүнд:

- 6.6.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Дагуулагчийн арилжааг дагах боломжтой платформыг талуудад санал болгох ба ашиг болон алдагдлын эрсдэлийг хариуцахгүй.
- 6.6.2 Дагуулагчийн арилжаа нь зах зээлд өндөр нөлөө үзүүлдэг мэдээний үед 1-3 секунд хоцорч Дагагчийн арилжааны дансанд биелэх эрсдэлийг хариуцахгүй.
- 6.6.3 Дагуулагч нь ашгийн болон алдагдлын хэмжээг амлах эрхгүй бөгөөд Дагагч нь ашиг, алдагдлыг өөрөө бүрэн хариуцана.

ДОЛОО.ХӨШҮҮРЭГ [/2025.08.14-ний нэмэлт, өөрчлөлт болно/](#)

- 7.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн нээлттэй арилжааны лотны хэмжээнээс хамаарч, мөн зах зээлд өндөр нөлөө үзүүлдэг мэдээний үед хэрэглэгчийн арилжааны дансны хөшүүргийг урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөх эрхтэй.
- 7.2 Энэхүү нөхцөлийг хүлээн зөвшөөрч, Үйлчилгээ үзүүлэгчийн веб сайтад бүртгэл үүсгэсэн хэрэглэгч нь нөхцөлийн 7.1-т заасан өөрчлөлтийн зөвшөөрлийг олгосонд тооцно.
- 7.3 Хэрэглэгчийн арилжааны дансны хөшүүрэг нь хослол бүрийн нээлттэй арилжааны лотны хэмжээнээс хамаарч дараах байдлаар өөрчлөгдөх ба энэхүү өөрчлөлт нь хэрэглэгчийн нээлттэй арилжаанд нөлөөлөхгүйгээр дараагийн шинэ арилжаанд хамааралтай болно.Үүнд:

Арилжааны дансны хөшүүрэг

Нээлттэй лотны хэмжээ	Хөшүүрэг
0.01-4.99 лот	Хэрэглэгчийн тохируулсан хөшүүрэг
5-9.99 лот	1:500
10-19.99 лот	1:300
20-49.99 лот	1:200
50 лот ба түүнээс дээш	1:100

- 7.4 Хэрэглэгчийн арилжаанд оролцсон лотны хэмжээнээс хамаарч энэхүү нөхцөлийн 7.3-т заасан хөшүүрэг өөрчлөгдөх боломжтой байна. /Жишээлбэл: Хэрэглэгч 6 лотоор арилжаанд орсон тохиолдолд 4.99 лот нь хэрэглэгчийн тохируулсан хөшүүргийн хэмжээгээр бодогдож, үлдсэн 1.01 лот нь 1:500 хөшүүргээр тооцогдох болно./
- 7.5 Үйлчилгээ үзүүлэгч нь зах зээлд өндөр нөлөө үзүүлдэг мэдээний өмнөх 5 минут болон мэдээний дараах 5 минутад бүх арилжааны дансны хөшүүрэг хамгийн ихдээ 1:200 хэмжээнд тохируулна.

НАЙМ.ХЯЗГААРЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

- 8.1. Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн бүртгэл болон арилжааны дансыг дараах тохиолдолд түр хязгаарлах, бүрэн хориглох, нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, арилжааны тохируулга хийх, компанийн хар жагсаалтанд оруулах, арилжааны үр дүнг хүчингүйд тооцох, гэрээ цуцлах, арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

Арилжааны дансыг түр хязгаарлах

- 8.1.1 Хэрэглэгчийн хувийн мэдээлэл зөрүүтэй, хуурамч, алдаатай, хуучирсан, бүрэн бус байх тохиолдолд;
- 8.1.2 Хэрэглэгчийн арилжааны түүхийг шалгах шаардлагатай, сэжигтэй тохиолдолд үүссэн тохиолдолд;
- 8.1.3 Хууль хяналтын байгууллагын шийдвэр, тогтоолыг үндэслэн.

Арилжааны дансыг бүрэн хориглох, нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, гэрээ цуцлах

- 8.1.4 Хэрэглэгч нь гуравдагч этгээдийн нэрээр бүртгэл үүсгэх, арилжаанд оролцох үйлдэл эс үйлдэхүй тогтоогдсон;
- 8.1.5 Үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн үйлчилгээний албаны ажилтантай зөв зохистой харилцаагүй, харилцан хүндэтгээгүй;
- 8.1.6 Хууль хяналтын байгууллагын шийдвэр, тогтоолыг үндэслэн.

Арилжааны үр дүнг хүчингүйд тооцож, компанийн хар жагсаалтанд оруулах

- 8.1.7 Энэхүү “Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ”, “Үйлчилгээний нөхцөл”-ийг зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй;
- 8.1.8 Хэрэглэгчийн бүртгэлийг ашиглан мөнгө угаах, хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлэх, түүнтэй ижил төрлийн хууль бус эх үүсвэртэй хөрөнгийг нуун дарагдуулсан, гүйлгээ хийсэн байж болзошгүй;
- 8.1.9 Хэрэглэгч арилжааг урвуулан ашигласан, системийн алдаа болон үйлчилгээний нөхцөл, энэхүү гэрээгээр зохицуулаагүй тулгамдаж буй асуудлыг үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдээгүй, залилан мэхлэх үйлдэл, эс үйлдэхүй гаргасан, үндэслэлгүй хөрөнгөжсөн;
- 8.1.10 Энэхүү үйлчилгээний нөхцөлийн 2.1.21-т заасан дүрэм зөрчсөн арилжаа хийсэн;

Арилжааны дансны тохируулга /2025.03.20-ны нэмэлт, өөрчлөлт болно/

- 8.1.11 Ролл-овер буюу гэрээний хугацаа дуусах үед дараагийн шинэ гэрээнд шилжих үед шинэ гэрээний үнэ хуучин гэрээний үнээс ялгаатай байгаагаас шалтгаалан хэрэглэгчийн арилжааны дансанд тохируулга буюу adjustment хийж свап нэмэх эсвэл хасах;
- 8.1.12 Хэрэглэгч өөрийн дансны хэмжээнд тохирох ЛОТ-ны хэмжээгээр арилжаагүй, ЛОТ-ны хэмжээг хэтрүүлсэн, маржин хэтрүүлж арилжсны улмаас арилжааны данс хасах Баланстай хаагдсан бол дансны тохируулга хийгдэхгүй; /2025.03.20-ны нэмэлт, өөрчлөлт болно/

САНАМЖ

1.Хэрэглэгч та манай <https://www.motcapital.com> веб сайтад бүртгүүлснээр энэхүү “Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ” болон “Үйлчилгээний нөхцөл”-ийг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Хэрэв та энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөлтэй санал нийлэхгүй бол өөрийн бүртгэлийг устгах, гэрээг цуцлах, манай үйлчилгээг бүрэн зогсоох эрхтэй болно.

2.Энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөлтэй холбоотой асуулт, тодруулах зүйл байвал манай харилцагчийн үйлчилгээний албаны support@motcapital.com цахим шуудангийн хаягаар бидэнтэй холбогдоно уу.

3.Манай “МОТ Капитал” ХХК нь хэрэглэгчтэй албан бус хаягаар харилцах, дансны бүртгэл, нэвтрэх нэр, нууц үг, зэрэг бусад хувийн мэдээллийг шаардахгүй тул мэдээллийн аюулгүй байдлаа сайтар хангаж, цахим залилангийн шинжтэй хууран мэхлэх үйлдлээс урьдчилан сэргийлнэ үү.

4.Манай “МОТ Капитал” ХХК нь "Promo Hunting" буюу үйл ажиллагааг залилан мэхлэх үйлдэл, эс үйлдэхүйг олж тогтоовол хэрэглэгчийн арилжааны үр дүнг цуцлах, дансыг хаах эрхтэй бөгөөд энэхүү үйлдэл нь бидэнд шууд мэдэгддэг болохыг анхаарна уу.



www.motcapital.com
support@motcapital.com